



Г ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН ДОРНОД АЙМГИЙН НАМЫН ХОРООНЫ ДАРГА Д.БАТ-ОРШИХ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.14 № 560

танай _____ -ны № _____ -т

Г Хандивын тайлангийн дүгнэлт Г

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох Иргэний зориг ногоон намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Иргэний зориг ногоон нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар"-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана. Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох Иргэний зориг ногоон намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг нийцлийн аудитын стандарт MNS 6817-8:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Иргэний зориг ногоон нам нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



011020744